



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3, 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдаж авсан нийт 730,000,000.00 (долоон зуун гучин сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Авлигатай тэмцэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга, эрхэлсэн комиссар 3.Баасаннямд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг бүртгэж авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ



0000160

Төрийн эмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 03 дугаар сарын 12 ны
өдрийн 68 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламж /хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ/-ний нэр	Ашиг лал танд орсон он	хөрөнгийн үнэ (төгрөг)	Тээврийн хэрэгслийн арлын дугаар
1	Тоёото Ландкрузер-200 маркийн, УНУ 12-89 улсын дугаартай, суудлын автомашин	2019	179,000,000.00	JTMHV01L404278372
2	Тоёото Ландкрузер-200 маркийн, УНУ 05-81 улсын дугаартай, суудлын автомашин	2019	166,000,000.00	JTMHU01JOK5155944
3	Тоёото Хайсе маркийн, УБУ 64-94 улсын дугаартай, суудлын автомашин	2019	98,000,000.00	JTFBNFCPX06002171
4	Хьюндай Серато маркийн, УНУ 47-57 улсын дугаартай, суудлын автомашин	2019	65,000,000.00	KNAF2416BK5858384
5	Хьюндай Оптима маркийн, УНУ 81-82 улсын дугаартай, суудлын автомашин	2019	74,000,000.00	KNAGU411BL5374970
6	Хьюндай Оптима маркийн, УНУ 01-94 улсын дугаартай, суудлын автомашин	2019	74,000,000.00	KNAGU411BL5363762
7	Хьюндай Оптима маркийн, УНУ 26-81 улсын дугаартай, суудлын автомашин	2019	74,000,000.00	KNAGU411BL5363763
			730,000,000.0	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		730,000,000.00 (долоон зуун гучин сая)	